


ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS
RESEARCH CENTER

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ
ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

МОНГОЛ УЛС: АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН 2019



МОНГОЛ УЛС: АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН 2019

(2018 оны статистик мэдээлэл ашиглав)

www.aimagindex.mn



The Asia Foundation



Харгалуулсан

giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH



ННА 65
ДАА 330
А-366

АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2019

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО,ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ

Сан бизнес центр 9-р давхар,
Ерөнхий сайд Амарын гудамж 29,
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот,
Монгол Улс

Утас: 976-11-321927
Факс: 976-11-321926

Аймгуудын өрсөлдөх чадварын тайлангийн цахим хуудас: www.aimagindex.mn
Цахим шуудан: info@ecrc.mn
Цахим хуудас: www.ecrc.mn ,
Фейсбүүк хуудас: <https://www.facebook.com/ursulduhchadvar>
Твиттер хуудас: <https://twitter.com/ursulduhchadvar>

ISBN 978-9919-23-148-4

© Зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан. Бүтээлийг зөвшөөрөлгүйгээр бүтнээр болон хэсэгчлэн хувилах,нийтлэх,ямар нэг хадгалах системд оруулахыг хориглоно.

ӨМНӨХ ҮГ



Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая!

Монгол Улс ардчилсан, зах зээлийн эдийн засагтай нийгэм рүү шилжих сонголт хийсний 30 жил, мөн манай Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв үүсгэн байгуулагдсаны 10 жилийн ойн баярын босгон дээр Аймгуудын өрсөлдөх чадварын 2019 оны тайланг толилуулж байгаадаа баяртай байна.

Монгол Улс өнгөрсөн 30 жилд хөгжлийн сайхан боломж, бас хүндрэл сорилтын аль алинтай нь нүүр тулсан. Хөгжлийн хувьд тоон үзүүлэлт биднийг гайхамшигтай амжилтад хүрснийг харуулдаг. Тухайлбал: Монгол хүний дундаж наслалт 7 жилээр нэмэгдэж (1992 онд – 63, 2018 онд – 70), хүн ам нэг саяар өсөж, ДНБ-ий зэрэгцүүлэх үнээр 3.5 дахин өсөж (1990 онд – 5.2 их наяд, 2018 онд – 18.1 их наяд буюу оны үнээр 1990 – 13 тэрбум төг, 2018 онд 32 их наяд төг), сэргээгдэх эрчим хүч, мэдээлэл технологийн ололтыг нэвтрүүлснээр хагас сая нүүдэлчид маань лааны гэрлээс ангижирч, холбоо, мэдээллийн хэрэглээний зөрүү эрс багасч, хамгийн гол нь Монгол Улс түүхэн сонголтондоо үнэнч байж бүс нутагтаа Ардчиллын төгөл хэмээн нэрлэгдэх боллоо.

Гэвч санхүү, төсөв, мөнгөний бодлогын уялдаа холбоо үе үе алдагдаж, хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг дэмжих ёстой хөгжлийн амин чухал бодлого нь сонгуулийн мөчлөг даган савлагаатай явж ирсний дээр улс төрийн нам, улс төрчдийн популист амлалт хөгжлийг чөдөрлөх, борцлох гол шалтгаан болж байна.

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв анх 2010 онд Монгол Улсын өрсөлдөх чадварын тайланг эрхлэн гаргаж байсан бол эдүгээ үйл ажиллагаа нь өргөжиж олон улсын байгууллагуудын захиалгат судалгаа хийхийн зэрэгцээ Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан, Дүүргүүдийн өрсөлдөх чадварын тайлан (2 жил тутамд) боловсруулж олон нийтийн хүртээл болгож ирлээ. Үүний сацуу Өрсөлдөх чадварын бүс нутгийн чуулган зохион байгуулж нийгэм, олон улсын байгууллагад танигдсан судалгааны төв болж, Дэлхийн судалгааны байгууллагуудын жагсаалтад орсон амжилттайгаар 10 жилийнхээ ойг угтаж байна.

“ТӨСВИЙН МӨНГӨ ГЭЖ БАЙДАГҮЙ ЗӨВХӨН ТАТВАР ТӨЛӨГЧИЙН МӨНГӨ ГЭЖ БАЙДАГ”

Улсын хөгжил аймаг орон нутгаас эхэлдэг. Аливаа төсөл ажлыг хийж хэрэгжүүлэхэд төсөв, санхүү хамгийн чухал. 2013 оноос Төсвийн хуульд нэмэлт өөрчлөлт орж, аймаг орон нутаг ихээхэн төсөв, санхүүгийн эрх мэдэлтэй болсон боловч төсвийн хуваарилалт, зарцуулалтыг тайлагнан хянаж, дүн шинжилгээ хийдэг тогтолцоо одоог хүртэл бүрдэж чадаагүй байна.

Зүй нь 2014 онд батлагдсан “Шилэн дансны тухай хууль”-ийг тууштай мөрдөж чадвал төсвийн

зарцуулалт, хяналтыг сайжруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, орон нутагт хөгжил урагшлах учиртай юм. Төсвийн мөнгө гэж байхгүй, зөвхөн татвар төлөгчдийн буюу иргэдийн халааснаас гарсан мөнгө гэж байдаг. Тийм болохоор иргэдийн оролцоо, хяналт бол зайлшгүй бөгөөд юугаар ч орлууламгүй үр ашигтай тогтолцоо болно.

Манай Төвийн судалгаа нь эрх баригчдад ажил төрлөө сайжруулахад нэн хэрэгтэй багаж. Хаана, ямар салбарт ахиц дэвшил гарав, бас хаана юу муудав, ухрав гэдгийг хэлж өгдөг ажлынх нь үр дүнгийн толь. Толинд өөрийг харсан хүн нэгийг боддог доо. Аймгуудад гарсан зарим зэрэг өөрчлөлтөөс дурдахад Дорноговь аймаг хамгийн их амжилт гаргаж, өрсөлдөх чадварын үзүүлэлтээ 10 оноогоор нэмэгдүүлж чадсан байна. Үүнд бизнесийн үр ашиг, дэд бүтцийн үзүүлэлт голлон нөлөөлжээ. Ховд аймаг 5, Дорнод, Өмнөговь аймаг тус бүр 3 оноогоор өрсөлдөх чадварын үзүүлэлтээ ахиулж чадлаа.

Энэ ялдамд, бидний ажлыг байнга дэмжиж ирсэн Германы Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялгийн иж бүрэн санаачилга хөтөлбөр, Азийн Сан болон бусад сайн санаат байгууллага, хувь хүмүүст гүн талархлаа илэрхийлье.

Хүндэтгэсэн,



Пунцагийн ЦАГААН

УЗ-ийн дарга, доктор (Ph.D)

СУДАЛГААНЫ БАГ

Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

Удирдах зөвлөлийн дарга П.Цагаан

Ерөнхий захирал Б.Лакшми

Дэд захирал И.Одончимэг

Судлаач Ч.Ганбат

Судлаач Э.Тунгалаг

Судлаач Х.Есөнчулуу

Судлаач Б.Мөнгөнжигүүр

Судлаач П.Мөнхшүр



EPCRC
ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS
RESEARCH CENTER
Эдийн засгийн бодлого, өрсөлдөх
чадварын судалгааны төв

ДЭМЖИГЧ БАЙГУУЛЛАГУУД



The Asia Foundation

Азийн Сан



германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Харгивуулагч:
giz

Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

ХБНГУ-ын Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг
Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага
хөтөлбөр



МОНГОЛЫН ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМ
Mongolian Fair Trade Association

Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
Орон нутаг дахь салбар танхимууд

СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ



Үндэсний
СТАТИСТИК

Үндэсний статистикийн хороо



Монгол Банк

Монголбанк

ГАРЧИГ

Товчилсон нэрсийн жагсаалт	9
ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ХУВЬСАЛ	10
СУДАЛГААНЫ ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ.....	13
АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ	19
Өрсөлдөх чадварын хүчин зүйлс.....	20
Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ 2019.....	21
Өрсөлдөх чадварын амжилтын хүрээ.....	27
АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	31
СТАТИСТИК ХҮСНЭГТҮҮД.....	117
1. Эдийн засгийн тамир тэнхээ.....	119
2. Засаглалын үр ашиг.....	131
3. Бизнесийн үр ашиг.....	143
4. Дэд бүтэц.....	155
БАЙГАЛЬ ОРЧНЫ ЭМЗЭГ БАЙДЛЫН ОЛОН ХУВЬСАГЧТАЙ ХЭМЖҮҮР ...	177
ХАВСРАЛТ.....	187
Өрсөлдөх чадвар судлалын тухай ерөнхий ойлголт.....	188
Мэдээллийн эх сурвалж, тайлбар.....	190

Аймгуудын өрсөлдөх чадварын төлөв байдал

АРХАНГАЙ	32
БАЯН-ӨЛГИЙ	36
БАЯНХОНГОР	40
БУЛГАН	44
ГОВЬ-АЛТАЙ	48
ГОВЬСҮМБЭР	52
ДАРХАН-УУЛ.....	56
ДОРНОГОВЬ	60
ДОРНОД	64
ДҮНДГОВЬ	68
ЗАВХАН	72
ОРХОН	76
ӨВӨРХАНГАЙ	80
ӨМНӨГОВЬ	84
СҮХБААТАР	88
СЭЛЭНГЭ	92
ТӨВ	96
УВС	100
ХОВД	104
ХӨВСГӨЛ.....	108
ХЭНТИЙ	112

Товчилсон нэрсийн жагсаалт


ААН	Аж ахуйн нэгж
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
МБ	Монголбанк
МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭЗБӨЧСТ	Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв

ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ХУВЬСАЛ

2012-2019 оны хооронд аймгуудын өрсөлдөх чадварын дундаж оноо жилээс жилд өсөж хандлагатай байна.

Энэ хугацаанд хамгийн тогтвортой өсөж байгаа бүлэг нь дэд бүтэц бөгөөд хамгийн тогтворгүй онооны хувьд өөрчлөлтүүд их байдаг бүлэг нь засаглалын үр ашиг юм.

График-1: Аймгуудын өрсөлдөх чадварын дундаж оноо 2012-2019 он



Энэ хугацаанд нэрлэсэн дүнгээр аймгуудын ДНБ-ий нийт хэмжээ 2.5 дахин нэмэгдсэн боловч Монгол Улсын ДНБ-д эзлэх хувь 34 хэвээрээ байна. Харин хүн ам зүйн талаас нь авч үзвэл 2011 онд бүс нутгуудаас шилжин явсан иргэдийн тоо шилжин ирсэн иргэдийн тооноос харьцангуй их байсан бол 2018 онд тэнцвэртэй болсон бөгөөд зарим бүсүүдэд шилжин ирсэн иргэдийн тоо шилжин явсан иргэдийн тооноос их байна. Тухайлбал 2011 онд Баруун бүсээс шилжин явсан иргэдийн тоо 10,767, шилжин ирсэн иргэдийн тоо 2,709 байсан бол 2018 онд шилжин явсан иргэдийн тоо 2,443, шилжин ирсэдийн тоо 2,635 болж өссөн. Бүх бүс

нутгуудын хувьд хүн амын шилжих хөдөлгөөн тогтворжих хандлагатай байна.

Хүснэгт 1: Хүн амын шилжих хөдөлгөөн

Шилжилт хөдөлгөөн	2011	2018
Баруун бүс	13,476	5,078
Шилжин ирсэн	2,709	2,635
Шилжин явсан	10,767	2,443
Зүүн бүс	7,104	5,972
Шилжин ирсэн	2,558	3,106
Шилжин явсан	4,546	2,866
Хангайн бүс	19,728	13,582
Шилжин ирсэн	6,016	7,025
Шилжин явсан	13,712	6,557
Төвийн бүс	24,975	23,711
Шилжин ирсэн	11,262	12,095
Шилжин явсан	13,713	11,616
Улаанбаатар	37,095	12,896
Шилжин ирсэн	28,593	6,568
Шилжин явсан	8,502	6,328

Эх сурвалж: YCX, www.1212.mn

Үүнийг илтгэх зарим үзүүлэлтүүд:

- Амьдралын чанар санал асуулга


Асуулт: Иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах нөхцөл сайн байна. /0-10 оноо/	2012 он	2019 он
Дундаж оноо	4.30	5.50
Хамгийн өндөр оноо	5.60	6.36
Хамгийн бага оноо	2.85	4.27

- Өрхийн орлого 2011-2018 оны хооронд бүх бүсэд 2 дахин нэмэгдсэн.
- Ажилгүй иргэдийн тоо буурсан.
- Орон сууцны барилгууд баригдсан.
- Замууд тавигдсан.

2019 оны үр дүнгээс:

Аймгуудын өрсөлдөх чадварын дундаж оноо өнгөрсөн жилээс 2 оноогоор буурсан. Аймгуудын дундаж онооноос харахад эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг бүлгүүд буурсан бол дэд бүтэц бүлэг өссөн байна.

График 2: Өрсөлдөх чадвар сайжирсан аймгууд




Дорноговь аймгийн бизнесийн үр ашиг, дэд бүтэц бүлгүүд сайжирсан. Үүнд худалдааны салбарын борлуулалт нэмэгдсэн, чанаргүй зээлийн үлдэгдэл буурсан, тохижилтын ажлууд, гэмт хэрэг буурсан, түгээлтийн сүлжээ сайжирсан нь нөлөөлжээ.

Ховд аймгийн хувьд засаглалын үр ашиг сайжирсан. Төсвийн тэнцэл, төсвийн удирдлага болон ил тод байдал сайжирсан нь нөлөөлжээ.

Дорнод аймагт дэд бүтэц сайжирсан. Үндсэн дэд бүтэц, технологийн дэд бүтэц бүлгүүд сайжирсан байна. Үүнээс дурдвал, холбооны салбарын орлого нэмэгдсэн, компаниудын зохицох чадвар сайжирсан, бүтээн байгуулалт засвар үйлчилгээ нэмэгдсэн зэрэг байна.

График 3: Өрсөлдөх чадвар муудсан аймгууд



Баян-Өлгий аймгийн хувьд дөрвөн бүлэг оноо буурсан. Аж үйлдвэрийн салбарын борлуулалт, шатахууны үнэ өссөн, төр хувийн хэвшлийн түншлэл муудсан, тендер, авлига хээл хахууль нэмэгдсэн.

Төв аймгийн эдийн засаг, засаглал, дэд бүтцийн

үзүүлэлтүүд буурсан. Дулаан, халаалтын үнэ нэмэгдсэн, аж үйлдвэр барилгын салбарын хөгжил болон эдийн засгийн төрөлжилт муудсан байна.

Сэлэнгэ аймгийн хувьд эдийн засаг, засаглал, бизнесийн үр ашиг муудсан. Төсвийн тэнцэл, барилгын ажил буурсан, аж үйлдвэрийн салбарын борлуулалтын ДНБ-д эзлэх хувь буурсан, амьдралын чанар муудсан зэрэг нөлөөлжээ.

Агаарын бохирдол

Цаашид аймгуудад нийтлэг тулгамдах асуудал бол агаарын бохирдол юм.

Агаарын бохирдлыг хэмжихдээ хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), $PM_{2.5}$, PM_{10} тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3)-ы агууламжийг автомат багаж болон химийн аргаар тодорхойлж байна¹.

Хүхэрлэг хий болон Азотын давхар исэл аймгийн төвүүдийн дундаж 0.011 мг/м^3 , 0.024 мг/м^3 бол Улаанбаатар хотод 0.019 мг/м^3 , 0.038 мг/м^3 байна. Энэ нь аймгийн төвүүдийн агаарын бохирдол Улаанбаатар хотынхоос дутахааргүй байгааг илтгэж байна. Баянхонгор, Орхон, Даланзадгад хотуудад тус үзүүлэлтүүд Улаанбаатар хотоос өндөр байна.

Иймд аймгийн төвүүдийн агаарын бохирдлын асуудлыг шийдэх зайлшгүй шаардлагатай тулгараад байна.

“Монгол Улс дахь засаглалын төвлөрлийг сааруулах, орон нутгийн засаглал ба эдийн засгийн хөгжлийн тухай”

Азийн хөгжлийн банк, Азийн сантай хамтран “Монгол Улс дахь засаглалын төвлөрлийг сааруулах, орон нутгийн засаглал ба эдийн засгийн хөгжлийн тухай” судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Орон нутагт хөрөнгө оруулалтын төсөв хязгаарлагдмал байдаг ч нутгийн удирдлагын хувьд хөрөнгө оруулалт хийх боломжууд байдаг ч тодорхой бэрхшээлүүдтэй тулгардаг гэдгийг уг тайланд дурьдсан байна. “Хөрөнгө оруулалтын төслүүдийг нийгэм-эдийн засгийн өгөөж, хөгжлийн үр нөлөөгөөр тодорхойлох, үнэлэх нарийн арга зүй шаардсан ажлыг хэрхэн хийх талаар практик зөвлөмж

¹ Байгаль орчны салбарын танилцуулга, ҮСХ, 2019 он

нутгийн удирдлагад өгдөггүй ба урсгал болон хөрөнгийн зардлын төсөвлөлт тусдаа хийгддэг нь хөрөнгө оруулалтын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг. Төрийн хөрөнгө оруулалт ба санхүүжилтийн үйл ажиллагаа стратегийн ямар үүрэг гүйцэтгэх ёстойг нутгийн удирдлагын байгууллагууд бүрэн ойлгодоггүй тул хувийн хэвшил хийвэл зохих төслүүдэд хөрөнгө оруулалт хийх нь түгээмэл. Томоохон төслүүдийн худалдан авах ажиллагааг төвөөс хэрэгжүүлдэг тул орон нутагт хөгжлийн үр нөлөө үзүүлэхгүй, бизнес эрхлэгчдэд боломж олддоггүй". Мөн түүнчлэн уг тайланд "засаг дарга нарын шийдвэр гаргах эрх хэмжээ өргөн цар хүрээтэй ч үүнийг хэрхэн үр дүнтэй, тэгш байдлыг ханган хэрэгжүүлэх талаар бодлогын удирдамж дутмаг байдаг" гэсэн байна.

СУДАЛГААНЫ ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ

Судалгааны зорилго, ач холбогдол

Монгол Улсын 21 аймгийн хөгжлийн өнөөгийн түвшинг харьцуулан үнэлэх, аймгуудын өрсөлдөх чадварыг цогц байдлаар тодорхойлоход оршино. Судалгаагаар аймаг бүрийн хөгжлийн давуу ба сул талыг тодорхойлж, өрсөлдөх чадварын боломж, чадавхыг үнэлэн тогтвортой, урт хугацааны хөгжлийн бодлого боловсруулахад ашиглахуйц өргөн хүрээний мэдээллийн сан бүрдүүлнэ.

Аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулж, өрсөлдөх чадварын чиг хандлагыг тодорхойлохоос гадна тухайн аймгийн өрсөлдөх чадварыг хойш татаж буй эсвэл дээшлүүлж буй үзүүлэлтүүдийг тогтоож, өрсөлдөх чадварын давуу, сул талыг үнэлэх боломж олгож буй нь энэхүү судалгааны давуу тал юм. Ингэснээр аль аймаг яагаад өрсөлдөх чадварын хувьд бусдаас сайн, эсвэл сул байгааг ойлгож мэдэх, тухайн аймаг давуу талаа хэрхэн ашиглаж болох, хөгжлийг хойш татаж буй сул талаа хэрхэн шийдвэрлэх шийдлийг олоход чухал эх үүсвэр болох юм.

Дашрамд дурдахад, уг судалгаа нь аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулан судалж буй тул өрсөлдөх чадвараараа тэргүүлсэн аймгуудыг өрсөлдөх чадвар сайтай гэж ойлгож болохгүй. Харин тэдгээр аймаг өрсөлдөх чадвараараа бусдаас харьцангуй илүү байгаа ч өөрийн өрсөлдөх чадварын сул үзүүлэлтүүдийг сайжруулах, давуу талаа

ашиглан илүү хурдтай хөгжих хэрэгтэйг харуулна. Үүний адилаар өрсөлдөх чадвараар сүүл мушгисан аймгуудын хувьд ч тухайн аймгууд өрсөлдөх чадвар муутай гэхээс илүү бусад аймагтай харьцуулахад өрсөлдөх чадвараар сул байна хэмээн ойлгож, бусад аймгаас хэрхэн суралцах, өөрийн өрсөлдөх чадварыг ямар үзүүлэлтүүд хойш татаж буйг тодорхойлж, тэдгээрийг сайжруулахад анхаарах нь зүйтэй.

Аймгуудын өрсөлдөх чадварын тайлан нь бодлого боловсруулагчдын хувьд аймгуудын өнөөгийн хөгжлийн түвшин, нөхцөл байдлыг бодитоор харж, орон нутгийг хөгжүүлэхэд чиглэсэн илүү үр ашиг бүхий шийдвэр гаргахад тус болохуйц мэдээллийн эх үүсвэр, гарын авлага байх юм. Түүнчлэн аймгийн удирдлагууд өөрийн бодлого шийдвэрүүдийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, бусад аймагтай харьцуулах, туршлага судлах боломжтой юм. Мөн ажил хэрэгч хүмүүс бизнесийн болон хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр гаргахдаа орон нутгийн талаарх найдвартай бөгөөд цогц мэдээллийг энэхүү тайлангаас авч болох билээ.

Мэдээллийн санг бүрдүүлэх хүрээнд www.aimagindex.mn сайтыг 2015 онд ашиглалтад оруулсан бөгөөд бүх жилүүдийн аймгуудын өрсөлдөх чадварын үзүүлэлтүүдийг харж болох ба өмнөх онуудтай харьцуулах боломжтой юм.

Аргачлал

1. Аймгуудын өрсөлдөх чадварын эрэмбийг тооцохдоо 4 үндсэн бүлэгт тулгуурласан
 - Эдийн засгийн тамир тэнхээ
 - Засаглалын үр ашиг
 - Бизнесийн үр ашиг
 - Дэд бүтэц
2. Үндсэн бүлэг тус бүр 4 дэд бүлгүүдэд хуваагдах ба нийт 16 дэд бүлгээс бүрдэнэ.
3. Эдгээр 16 дэд бүлэг нь нийт 176 үзүүлэлтээс бүрдэнэ.
4. 176 үзүүлэлтийн 148 үзүүлэлтээр өрсөлдөх чадварын индексийг тооцон эрэмбэлдэг. Эдгээр 148 үзүүлэлтийн 74 нь статистик мэдээлэл, 74 нь санал асуулгаас бүрддэг.
5. Дэд бүлэг доторх үзүүлэлтийн тоо ялгаатай байх бөгөөд судалгааны үр дүнг бодитой, тэнцвэртэй байлгах үүднээс дэд бүлэг бүрийн эзлэх жинг дотроо хэдэн үзүүлэлттэйгээс үл хамааран тэнцүү ($16 \times 6.25\% = 100\%$) хэмжээтэй сонгосон.
6. 16 дэд бүлгээр тооцсон аймгуудын дундаж стандартчилсан үнэлгээнд суурилан 16 бүлгийн өрсөлдөх чадварын индексийг аймаг бүрээр дараах ерөнхий томъёогоор тооцоолно.

$$I = \frac{STD(x) - STD_{min}(x)}{STD_{max}(x) - STD_{min}(x)}$$

Энд:

I – өрсөлдөх чадварын индекс

$STD(x)$ – шалгуур үзүүлэлтийн стандарт үнэлгээ


$STD_{min}(x)$ - шалгуур үзүүлэлтийн стандарт үнэлгээний хамгийн бага утга

$STD_{max}(x)$ - шалгуур үзүүлэлтийн стандарт үнэлгээний хамгийн их утга

Аймгуудын өрсөлдөх чадварыг хэмжих үзүүлэлтүүд

Үндсэн хүчин зүйлс	Эдийн засгийн тамир тэнхээ	Засаглалын үр ашиг	Бизнесийн үр ашиг	Дэд бүтэц
Дэд хүчин зүйлс	<ul style="list-style-type: none"> • Эдийн засаг • Эдийн засгийн салбарууд • Хүн амын амьжиргааны түвшин • Хөдөлмөр эрхлэлт 	<ul style="list-style-type: none"> • Аймгийн төсөв • Институцийн тогтолцоо • Бизнесийн эрхзүй • Нийгмийн тогтолцоо 	<ul style="list-style-type: none"> • Бизнесийн орчин • Хөдөлмөрийн зах зээл, бүтээмж • Санхүү • Менежментийн хэвшил 	<ul style="list-style-type: none"> • Үндсэн дэд бүтэц • Технологийн дэд бүтэц • Боловсрол, соёл • Эрүүл мэнд, хүрээлэн буй орчин

Эрэмбэ тооцох арга



Аймгуудын өрсөлдөх чадварын тайланг хэрхэн ашиглах вэ?

Аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээг дараах ерөнхий хэсгүүдээс харах боломжтой. Үүнд:

1. Аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээ (21-30 хуудас)

Аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээ нь 21 аймгийн нэгтгэсэн эрэмбэлэлээс тодорхой харагдана. Аймгууд өрсөлдөх чадвар хамгийн сайтайгаасаа эхлэн эрэмбэлэгдэнэ.

“Өрсөлдөх чадварын ерөнхий ба үндсэн хүчин зүйлсийн эрэмбэ”

Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээнээс гадна өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйлс болох эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг, дэд бүтэц тус бүрээр өрсөлдөх чадварын үнэлгээг харж болно.

“Өрсөлдөх чадварын дэд хүчин зүйлсийн эрэмбэ”

Өрсөлдөх чадварын үндсэн хүчин зүйл бүрийн 4 дэд хүчин зүйл буюу нийт 16 дэд хүчин зүйлийн эрэмбийг энэ хэсэгт багтаасан. Дэд бүлгүүдийн эрэмбэ нь тухайн үндсэн бүлэг бүрийн эрэмбийг илүү тодруулан. нарийвчлан харуулах юм.

“Өрсөлдөх чадварын амжилтын хүрээ”

Энэ хэсэгт аймаг бүрийн өрсөлдөх чадварын үндсэн 4 хүчин зүйлийн үнэлгээг 21 аймгийн дундаж үзүүлэлттэй харьцуулан харуулна. Торон графикийн тусламжтайгаар тухайн аймаг ямар үзүүлэлтээр илт давуу болон сул талтай болохыг харах боломжтой.

2. Аймгуудын өрсөлдөх чадварын төлөв байдал (31-115 хуудас)

Энэ бүлэгт аймаг тус бүрийн эдийн засгийн ерөнхий байдал, өрсөлдөх чадварын амжилтын хүрээ, өрсөлдөх чадварын дэд хүчин зүйлсийн эрэмбэ, тухайн аймгийн хөгжилд тулгарч буй саад бэрхшээл, шийдвэрлэх асуудлыг нэгтгэн харуулсан.

Түүнчлэн өрсөлдөх чадварын 4 үндсэн хүчин зүйл болох эдийн засгийн тамир тэнхээ, засаглалын үр ашиг, бизнесийн үр ашиг, дэд бүтэц тус бүрийн 10 сул болон 10 давуу талыг тодотгон үзүүлсэн. Аймгийн эдийн засгийн орчин, ирээдүйн хөгжилд ач холбогдолтой өрсөлдөх чадварын давуу болон сул талыг тогтоох нь тун чухал. Учир нь тухайн аймаг өөрийн өрсөлдөх чадварын хамгийн сайн, давуу талдаа тулгуурлан хөгжиж, баялгийг бүтээдэг. Түүнчлэн давуу талаа ашиглахын зэрэгцээ сул талаа хянаж, сайжруулах нь аймгуудын өрсөлдөх чадварыг сайжруулахад түлхэц болно.


Мөн аймгуудын өрсөлдөх чадварыг хооронд нь харьцуулахаас гадна Өрсөлдөх чадварын хувьсал хэсгээс тухайн аймгийн өрсөлдөх чадварын үзүүлэлтийг өмнөх жилтэй нь харьцуулсан 25 өсөлт, 25 бууралтыг харах боломжтой.

3. Статистик хүснэгт (117-176 хуудас)

Энэ хэсэгт өрсөлдөх чадварын хүчин зүйлсийг тодорхойлж буй шалгуур үзүүлэлтийг дэлгэрэнгүй багтаасан. Эндээс өрсөлдөх чадварт нөлөөлж буй 150 шалгуур үзүүлэлт бүрийн эрэмбэ, мэдээллийг харж болно.

АЙМГУУДЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ

Өрсөлдөх чадварын хүчин зүйлс



Өрсөлдөх чадварын ерөнхий үнэлгээ 2019

